

**ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН
СУРТАЛЧИЛГААНЫ БОЛОН МЭТГЭЛЦЭЭНИЙ ТӨЛБӨРГҮЙ НЭВТРҮҮЛГИЙН ХУВААРЬ,
ЦАГТ ХЯНАЛТ ТАВЬСАН ТУХАЙ**

Тайлангийн хамрах хугацаа: **2024.06.10-06.28**

2024.07.05-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсэгт заасан чиг үүргийн дагуу Олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх санал, уг саналыг гаргахад баримталсан аргачлал, мэтгэлцээний нэвтрүүлгийн дэгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хууль, журамд заасан зарчимд нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, тус Хорооны 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хуралдааны 129 дугаар тогтоолын



- ✓ Нэгдүгээр хавсралтаар “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”;
- ✓ Хоёрдугаар хавсралтаар “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”-ийг тус тус батлан гаргасан.

Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 6-р сарын 06-ны өдрийн Хуралдаанаар нэр дэвшигчдийг дахин бүртгэх асуудлыг хэлэлцэж, 15 нам, 2 эвслээс 89 нэр дэвшигч, 3 бие даагч нийт 92 хүнийг нэр дэвшигчээр нэмж бүртгэх шийдвэр гарсантай холбоотой МҮОНРТ-ээс ирүүлсэн Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн дээрх батлагдсан хуваарь цагт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Харилцаа холбооны зохицуулах Хорооны 2024 оны 6-р сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, тус Хорооны 130 тоот тогтоолоор дээрх хуваарь, цагуудад холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан.

Тус хорооноос дээрх батлагдсан хуваарь, цагуудыг 21 нам, эвсэл, 39 бие даагчдад албан бичгээр хүргүүлж, цахим хуудсаар мэдээлж ажилласан болно.

Иймд хуульд заасан чиг үүргийн дагуу Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт дараах чиглэлээр хяналт, мониторинг хийж ажилласан. Үүнд:

- Батлагдсан хуваарь цагийн дагуу сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх
- Мэтгэлцээний нэвтрүүлгийг үндсэн сувгаар, батлагдсан хуваарь, цагийн дагуу нэвтрүүлсэн эсэх
- Сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлсэн эсэх

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өмнөх 2020 оны сонгуулиас ялгаатай орсон заалтын тухайд МҮОНРТ нь сонгуулийн сурталчилгаанд хуваарилсан нийт цагтай тэнцүү хэмжээний цагийг мэтгэлцээний нэвтрүүлэгт хуваарилахаар заасан. (Тус хуулийн 46.4)

МҮОНРТ-ээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн цаг хуваарилсан байдлыг авч үзэхэд:

МҮОНРТ нь эфирийн нийт цагийн 71%-ийг сонгуулийн сурталчилгаа болон мэтгэлцээний нэвтрүүлэгт хуваарилсан байна.



№	Эфирийн цаг	1 хоногт	17 хоногт
1	Хоногийн нийт эфир	1020 мин	17340 мин
2	MNB үндсэн эфир (29%)	300 мин	5100 мин
3	Сонгуульд зарцуулах (71%)	720 мин	12240 мин
3.1	Сурталчилгааны нэвтрүүлэг	360 мин	6120 мин
3.2	Мэтгэлцээний нэвтрүүлэг	360 мин	6120 мин

МУ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.4-д заасны дагуу МҮОНРТ нь сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн цагийг нийт сонгуулийн сурталчилгааны 17 хоногийн хугацаанд тэнцүү байхаар тооцож, тус бүр 6120 минутыг хуваарилж олгосон байна.

МҮОНРТ нь сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн цаг хуваарилахдаа Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 46.3 болон 46.12-т заасны дагуу сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах зарчмыг баримталсан болно.

МҮОНТ-ИЙН МNВ СУВГААР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ТӨЛБӨРГҮЙ НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАН

6-р сарын 10-26-ны өдрүүд

МҮОНТ-ээр 19 нам, 2 эвсэл түүнчлэн 42 бие даан нэр дэвшигчдийн нийт 404 удаагийн 101 цагийн төлбөргүй нэвтрүүлэг нэвтрүүлэх хуваарь, цаг батлагдсан. Батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн байдалд хяналт, мониторинг хийлээ.

MNB сувгаар сонгуулийн сурталчилгааны нийт хугацаанд 19 нам, 2 эвсэл, бие даан нэр дэвшигчдийн нийт 381 удаагийн 92 цаг 29 минутын сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.

Нийт батлагдсан хуваариас Ардчилсан нам, Монголын либерал ардчилсан нам, Эх орончдын нэгдсэн нам тус бүр 1 удаа, мөн 20 бие даан нэр дэвшигчийн нэвтрүүлэг хуваарьт цагтаа гараагүй бол бусад бүх нэвтрүүлэг хуваарьт цагтаа эфирт гарчээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.18-т заасны дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн батлагдсан хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглосон. Түүнчлэн МҮОНТ-ийн Ерөнхий захирлын 2024 оны 5-р сарын 27-ны өдрийн А/33 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн цаг хуваарилах журмын 2.14.3-т заасны дагуу батлагдсан хуваарь, цагт нэвтрүүлгээ хүлээлгэн өгөөгүй тохиолдолд цагийг нөхөн олгохгүй гэж заасан. Сурталчилгааны хугацаанд бүх цагууд хуваарилагдсан байгаа тул нөхөн олгох боломжгүй юм.

Иймд дээрх хуваарь цагтаа сурталчилгааны нэвтрүүлгээ өгөөгүй эсхүл биеэр ирж оролцоогүй цагийг бусад нам, эвсэл, бие даагчдад шилжүүлээгүй болно.


MNB СУВГААР НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Нам, эвсэл, бие даагч	Хуваарь өдөр, цагтаа		Нийт нэвтрүүлгийн цаг
		гарсан	гараагүй	
1	Иргэний хөдөлгөөний нам	35	-	8:41:26
2	Монгол ардын нам	35	-	8:35:06
3	Ардчилсан нам	34	1	8:20:51
4	Хөдөлмөрийн үндэсний нам	34	-	8:20:01
5	Шинэ нэгдсэн эвсэл	25	-	6:08:30
6	Үнэн ба Зөв нам	22	-	5:25:48
7	Ард түмний олонхийн засаглал нам	20	-	4:59:00
8	Иргэний зориг ногоон нам	20	-	4:56:45
9	Үндэсний эвсэл	18	-	4:22:36
10	Ард түмний хүч нам	17	-	4:03:23
11	Иргэдийн оролцооны нэгдэл нам	16	-	3:57:35
12	Бүгд найрамдах нам	15	-	3:10:22
13	Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	15	-	3:44:29
14	Эрх чөлөөний эвсэл нам	13	-	3:12:36
15	Монголын хүний төлөө нам	12	-	3:00:21
16	Эх орон нам	12	-	2:13:11
17	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	8	-	2:00:46
18	Монгол консерватив нам	6	-	1:29:47

19	Монголын социал демократ нам	2	-	0:25:33
20	Бие даагч	22	20	5:21:10
21	Монголын либерал ардчилсан нам	-	1	-
22	Эх орончдын нэгдсэн нам	-	1	-
Нийт		381	23	92:29:16

MNB сувгаар сонгуулийн сурталчилгааны нийт хугацаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн нийт 381 удаагийн 92 цаг 29 минутын нэвтрүүлэг нэвтрүүлсний 33 цаг 42 минутын нь дохионы хэлмэрчтэй, 5 цаг 20 минут нь бичгэн тайлбартай нэвтрүүлэг байна.

Дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлгийн нийт нэвтрүүлэгт эзлэх хувь, цаг



НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААГЧИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛГИЙН ДОХИОНЫ ХЭЛ, БИЧГЭН ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Нам, эвсэл, бие даагч	Нийт нэвтрүүлгийн цаг	Дохионы хэлтэй	Бичгэн тайлбартай	Дохионы хэл, бичгэн тайлбаргүй нэвтрүүлгийн нийт цаг
1	Иргэний хөдөлгөөний нам	8:41:26	-	-	8:41:26
2	Монгол ардын нам	8:35:06	8:35:06	-	-
3	Ардчилсан нам	8:20:51	7:21:43	0:14:15	0:44:53
4	Хөдөлмөрийн үндэсний нам	8:20:01	4:09:17	0:12:58	3:57:46
5	Шинэ Нэгдсэн эвсэл	6:08:30	-	0:14:24	5:54:06
6	Үнэн ба Зөв нам	5:25:48	5:25:48	-	-
7	Бие даагч	5:21:10	0:14:25	0:12:26	4:54:19
8	Ард түмний олонхийн засаглал нам	4:59:00	-	-	4:59:00
9	Иргэний зориг ногоон нам	4:56:45	2:58:50	0:58:36	0:59:19
10	Үндэсний эвсэл	4:22:36	4:07:35	-	0:15:01
11	Ард түмний хүч нам	4:03:23	-	0:13:24	3:49:59
12	Иргэдийн оролцооны нэгдэл нам	3:57:35	-	-	3:57:35
13	Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам	3:44:29	-	3:14:14	0:30:15
14	Эрх чөлөөний эвсэл нам	3:12:36	-	-	3:12:36
15	Бүгд Найрамдах Нам	3:10:22	-	-	3:10:22
16	Монголын хүний төлөө нам	3:00:21	-	-	3:00:21

17	Эх орон нам	2:13:11	0:49:59	-	1:23:12
18	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	2:00:46	-	-	2:00:46
19	Монгол Консерватив Нам	1:29:47	-	-	1:29:47
20	Монголын социал демократ нам	0:25:33	-	-	0:25:33
Нийт		92:29:16	33:42:43	5:20:17	53:26:16

Сонгуульд өрсөлдөгч нам, эвслүүдээс Монгол Ардын нам, Үнэн ба Зөв нам бүх нэвтрүүлгээ, Үндэсний эвсэл нийт нэвтрүүлгийнхээ 96% орчмыг, Ардчилсан нам 90% орчмыг, ХҮН болон Иргэний зориг ногоон нам 50% орчмыг тус тус дохионы хэлмэрчтэй бэлтгэн нэвтрүүлжээ.

МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

МҮОНТ

6-р сарын 10-26-ны өдрүүд

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн сурталчилгааны тухайд өмнөх сонгуулиудаас ялгаатай нь МҮОНРТ нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.4-д заасны дагуу нийт сонгуулийн сурталчилгааны 17 хоногийн хугацаанд сонгуулийн сурталчилгаанд хуваарилсан цагтай тэнцүү хэмжээний цагийг мэтгэлцээний нэвтрүүлэг зохион байгуулж нэвтрүүлэхэд хуваарилах үүрэгтэй юм.

Энэ чиг үүргийн дагуу сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн цаг тэнцүү байхаар тооцож, тус бүр 6120 минутыг хуваарилж олгосон бөгөөд нийт эфирийн 70%-ийг сонгогчдод сонгуульд өрсөлдөж байгаа нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, тэдний үзэл баримтлал, байр суурийг таниулахад зарцуулж, цагаа үнэ төлбөргүй олгосон.

MNB үндсэн сувгаар 6 сарын 10-26 өдрүүдэд нийт 51 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэхээр төлөвлөсний дагуу нэвтрүүлсэн байна.

MNB сувгийн мэтгэлцээн нь 6-р сарын 10-25-ны өдрүүдэд өдөрт 2 цагаар нэг удаагийн нэвтрүүлэгт 5 оролцогчтойгоор, 6-р сарын 26-ны өдөр 4 цаг үргэлжлэх нийт нам, эвслийн төлөөлөл түүнчлэн бие даан нэр дэвшигчдийг оролцуулахаар төлөвлөгдсөн бөгөөд оролцогч нэр дэвшигч бүрд асуултад хариулах ижил хугацаа олгохоор дэгт тусгажээ. Тухайн мэтгэлцээнд оролцогчийн тооноос хамааран мэтгэлцээний тухайн нэвтрүүлгийн нийт үргэлжлэх хугацаа ялгаатай байсан бөгөөд сонгуулийн сурталчилгааны нийт өдрүүдэд нийт 51 удаагийн 72 цаг 58 минутын мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Тухайн мэтгэлцээнийг 2 үндсэн үед хувааж 2 өөр сэдвийн хүрээнд өрнүүлсэн бөгөөд нам, эвслүүд сэдвээс хамаарч өөр өөр оролцогч оролцуулах тохиолдол их байлаа.

Энэ нь нам, эвсэл, бие даагчдад танилцуулж, хэлэлцүүлсний дагуу Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирлын тушаалаар батлан гаргасан "Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд өрсөлдөгч улс төрийн нам, эвсэл нэр дэвшигчдийн мэтгэлцээний дэг"-ийн 2.9-д "Сонгуулийн сурталчилгааны 17 хоногт 1 мэтгэлцээнд 2 сэдвээр мэтгэлцэх тул нам, эвсэлд сэдэв тус бүрд нэр дэвшигчээ сольж оролцуулах эрх нээлттэй байна" гэсний дагуу сэдвээс хамааран нэр дэвшигчид солигдож байв.

Хуваарийн дагуу 6-р сарын 10-25-ны өдрүүдийн өдөр бүр 2 цаг үргэлжлэх нийт 50 удаагийн, 6-р сарын 26-ны өдөр 3 цаг 51 минут үргэлжилсэн 1 мэтгэлцээн зохион байгуулж нэвтрүүлснээр сонгуулийн сурталчилгааны 17 өдөр нийт 51 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэгт 18 нам, 2

эвсэл, түүнчлэн 14 бие даан нэр дэвшигч сонгуулийн мэтгэлцээнд оролцсон бол бусад 28 бие даан нэр дэвшигч мэтгэлцээнд оролцоогүй байна. Ард түмний хүч нам, Иргэний зориг ногоон нам, Монголын консерватив нам, Монголын социал демократ нам, Монголын хүний төлөө нам, ХҮН нам, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам, Эрх чөлөөний эвсэл нам, Эх орон нам гэсэн 9 нам мэтгэлцээнд бүх хуваарь, цагтаа төлөөллүүд бүрэн оролцуулсан байна.

Харин Ард түмний олонхын засаглал нам, Ардчилсан нам, Бүгд найрамдах нам, Монгол ардын нам, Үнэн ба зөв нам, Шинэ нэгдсэн эвслээс тус бүр 1 удаа мэтгэлцээнд төлөөлөл оролцоогүй бол Иргэдийн оролцооны нэгдсэн нам, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, Үндэсний эвслээс тус бүр 2 удаа мэтгэлцээнд оролцоогүй байна.

Эх орончдын нэгдсэн нам 2 удаа, Иргэний хөдөлгөөний нам 1 удаа л мэтгэлцээнд оролцсон бол Монголын либериаал ардчилсан намаас мэтгэлцээнд огт оролцоогүй байна.

№	Нам, эвсэл, бие даагч	Оролцох хуваарьт тоо	Үүнээс:	
			Оролцсон	Оролцоогүй
1	Ард түмний хүч нам	11	11	-
2	Иргэний зориг ногоон нам	11	11	-
3	Монгол консерватив нам	11	11	-
4	Монголын Социал Демократ Нам	11	11	-
5	Монголын хүний төлөө нам	11	11	-
6	ХҮН нам	11	11	-
7	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	11	11	-
8	Эрх чөлөөний эвсэл нам	11	11	-
9	Эх орон нам	11	11	-
10	Ард түмний олонхийн засаглал нам	11	10	1
11	Ардчилсан нам	11	10	1
12	Бүгд найрамдах нам	11	10	1
13	Монгол ардын нам	11	10	1
14	Үнэн ба зөв нам	11	10	1
15	Шинэ нэгдсэн эвсэл	11	10	1
16	Иргэдийн оролцооны нэгдэл нам	11	9	2
17	Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	11	9	2
18	Үндэсний эвсэл /МНН-МҮАН/	11	9	2
19	Эх орончдын нэгдсэн нам	9	2	7
20	Иргэний хөдөлгөөний нам	11	1	10
21	Монголын либериаал ардчилсан нам	10	-	10
22	Бие даан нэр дэвшигч (6 сарын 10-25 өдрүүдэд)	42	12	30
23	Бие даан нэр дэвшигч (6 сарын 26 өдөр)	Зөвхөн оролцох хүсэлтээ илэрхийлсэн бие даагчид	13	-
Нийт		270	214	69

Үүнээс сонгуульд нэр дэвшигч бүх нам, эвслийн төлөөлөл болон бие даан нэр дэвшигчид оролцох 6-р сарын 26-ны өдрийн нэгдсэн мэтгэлцээнд 16 нам, 2 эвслийн төлөөлөл болон 13

бие даагч оролцсон бол Ард түмний олонхын засаглал нам, Монголын либерал ардчилсан нам, Эх орончдын нэгдсэн намаас төлөөлөл оролцоогүй байна.

Нийт 51 удаагийн мэтгэлцээнд оролцсон оролцогчдыг авч үзвэл давхардсан тоогоор 368 нэр дэвшигч байна.

МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧДИЙН ТОО
/давхардсан тоогоор/

№	Нам, эвсэл, нэр дэвшигч	Мэтгэлцээнд оролцсон оролцогчийн тоо
1	Хөдөлмөрийн үндэсний нам (ХҮН)	20
2	Иргэний зориг ногоон нам	20
3	Бүгд Найрамдах Нам	20
4	Монголын социал демократ нам	20
5	Монголын хүний төлөө нам	20
6	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	20
7	Эрх чөлөөний эвсэл нам	20
8	Эх орон нам	20
9	Ард түмний хүч нам	19
10	Шинэ Нэгдсэн эвсэл	18
11	Ард түмний олонхийн засаглал нам	18
12	Иргэдийн оролцооны нэгдэл нам	18
13	Монгол ардын нам	17
14	Ардчилсан нам	17
15	Үндэсний эвсэл	16
16	Үнэн ба Зөв нам	16
17	Монгол Консерватив Нам	16
18	Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам	13
19	Иргэний хөдөлгөөний нам	2
20	Эх орончдын нэгдсэн нам	1
21	Бие даан нэр дэвшигч	37
	Нийт	368